



Сэтгүүлчийн эрхийн зөрчил

“Хэнтийн мэдээ” сонины эрхлэгч шүүхэд дуудагджээ

Тус сонины эрхлэгч Б.Батцэцэг иргэн Г.Баатар, Ж.Багаа нарын нэхэмжлэлээр Хэнтий аймгийн сум дундын шүүхэд дуудагдсан байна.

Б.Батцэцэг шүүхэд гаргасан тайлбартаа “Манай сонин төлбөртэй материал, зар сурталчилгааны орлогоороо голлон санхүүждэг тул төлбөртэй материалыг нам, улс төр, бизнес, хувь хүний гэж ялгалгүй авч нийтэлдэг. Манай сонины 2008 оны 11-р сарын № 7 дугаарт “МАХН-ын салбар хорооны гишүүд согтуу байжээ” гарчигтай материал нь төлбөртэй нийтлэгдсэн тул нийтлэлийн хариуцлагыг захиалагч тал хариуцна гэж үзэж байна. Манай сонин “нийтлэгдсэн материалын хариуцлагыг зохиогч хүлээн...” гэсэн тодруулгыг байнга тавьдаг. Хэнтий аймгийн ИТХ-ын дарга асан П.Баярт тус сонинд нийтлүүлсэн “Иргэдийн сонголтонд хэн ч халдах ёсгүй”, “МАХН-ын салбар хорооны гишүүд согтуу байжээ”, “Унасан бөхөд шалтаг мундахгүй” зэрэг материалын төлбөрт 220 000 төгрөг төлсөн. Тиймээс нэхэмжлэгчийн гаргасан 2 сая төгрөгийг төлөх боломжгүй” гэсэн байна.



Дэлхий дахинд хэвлэлийн эрх чөлөө – 2008 онд

Хэвлэлийн эрх чөлөөний төлөө “Хил хязгааргүй сэтгүүлчид” байгууллагаас жил бүр ажил үүргээ гүйцэтгэж яваад хохирогч болсон зөрчлүүдийг нэгтгэн мэдээлдэг. 2008 онд Ази Номхон далай, Зүүн Өмнөд Азийн бүст сэтгүүлч хэвлэн нийтэлснийхээ төлөө амиа алдах нь элбэг хэвээр байна. Алагдсан сэтгүүлчийн тоогоор Ирак (15 сэтгүүлч алагдсан)-ийн дараа Пакистан (7), Филиппин (6), Мексик (4) орж байна.

2007 онд алагдсан сэтгүүлчдийн тоогоор хамгийн өндөр байсан Африкт 2008 онд 3 болж багассан нь Самоли зэрэг дайны бүс нутагт сэтгүүлчид ажлаа орхисонтой холбоотой. 48 цагаас илүү хугацаагаар баривчлагдсан сэтгүүлчдийн тоогоороо Африк өндөр байна.

2008 онд:

- 60 сэтгүүлч алагдсан
- 1 хэвлэл мэдээллийн ажилтан алагдсан
- 673 сэтгүүлч баривчлагдсан
- 929 бие махбодын халдлага, довтолгоонд өртсөн
- 353 хэвлэл мэдээллийн хэрэгсэл цагдан хянагдсан
- 29 сэтгүүлч барьцаалагдсан

Интернет:

- 1 блог эрхлэгч алагдсан
- 59 блог эрхлэгч баривчлагдсан
- 45 сэтгүүлч халдлагад өртсөн
- 1,740 вэбсайт блоклогдож, хаагдаж, үйл ажиллагааг зогсоосон

Дэлгэрэнгүйг

http://www.rsf.org/article.php?id_article=29797

Member of



www.ifex.org



www.internews.org



www.forum-asia.org

Мэдээ

Эрх хэмжээний бус шийдвэр гаргаж байгааг буруушаав

Баян-Өлгий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /ИТХ/-ын тэргүүлэгчдийн хурлаас олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад хүргэсэн эрх хэмжээний бус шийдвэр гаргаж байгаад “Глоб Интернэшнл” ТББ буруушаав.

Баян-Өлгий аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар олон нийтийн радио, телевизийн салбарын өмчлөлийн асуудлыг хэлэлцэн гаргасан шийдвэр нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай болон ОНРТ-ийн тухай хуулийг ноцтой зөрчсөн үйлдэл тул эрх зүйн үндэслэлгүй 2008 оны 128 дугаар тогтоолоо хүчингүй болгож, орон нутгийн радио, телевизийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байхыг Баян-Өлгий аймгийн ИТХ-ын дарга Х.Баян, аймгийн засаг дарга С.Хавал нарт хандан шаардлага хүргүүлэв.

“Глоб Интернэшнл” ТББ “Хэвлэл мэдээллийн хөгжлийн бүх дэлхийн форум”-ын гишүүн боллоо

“Хэвлэл мэдээллийн хөгжлийн бүх дэлхийн 2-р форум” Хеллений Бүгд Найрамдах улсын ерөнхийлөгч, эрхэмсэг ноён Каролос Папоулиасын ивээл доор Грекийн нийслэл Афин хотноо боллоо. Дэлхийн өнцөг булан бүрээс цугларсан 500 гаруй хэвлэл мэдээллийн салбарын мэргэжилтнүүд “Бүгдэд зориулсан чанартай мэдээлэл” сэдвийн доор глобалчлагдаж буй дэлхий дахины хэвлэл мэдээллийн өмнө тулгарч буй асуудлуудыг хэлэлцсэн бөгөөд Монгол улсаас энэхүү хуралд “Глоб Интернэшнл” ТББ-ын “Бизнесийн мэдээлэл” төслийн мэдээллийн агентлагийн захирал Ч.Мөнхзул оролцоод ирлээ.

Форумын үеэр “Глоб Интернэшнл” ТББ “Хэвлэл мэдээллийн хөгжлийн бүх дэлхийн форум”-ын гишүүн болсон юм. Ингэснээр “Хэвлэл мэдээллийн хөгжлийн бүх дэлхийн форум”-д Монгол улсаас элссэн анхны байгууллага болж байгаа бөгөөд дэлхий дахинд хэвлэл мэдээллийн хөгжлийн асуудлаар ажилладаг бүх байгууллагуудтай байнга мэдээлэл солилцох, хамтран ажиллах боломжтой болж байна.

“Хэвлэл мэдээллийн хөгжлийн бүх дэлхийн форум” нь хэвлэл мэдээллийн хөгжлийн асуудлаар ажилладаг байгууллагуудад тогтвортой үйл ажиллагаа явуулах, санхүүжилт олох, дэлхийн томоохон донор байгууллагуудтай ажиллахад нь дэмжиж, туслах чиглэлээр түлхүү ажиллахаар шийдвэрлэсэн юм.

Дэлгэрэнгүй мэдээллийг: www.gfmd-athensconference.com

Монголын Шинжлэх ухааны Сэтгүүлчдийн клубын анхдугаар чуулган болов

Монголын хэсэг эрдэмтдийн санаачилгаар байгуулагдсан Монголын Шинжлэх ухааны Сэтгүүлчдийн клубын анхдугаар чуулганаар Др.Проф С.Буднямын “Шинжлэх ухааныг сурталчлах хэрэгтэй юу?” илтгэлийг сонсож, зохион байгуулалтын асуудал хэлэлцсэн байна. Тус клубын гүйцэтгэх захирал Др.Проф Ш.Батмөнх “Бид Дэлхийн Шинжлэх ухааны Сэтгүүлчдийн холбооноос сэтгүүлчдэд зориулан гаргадаг он-лайн хичээлүүдийг www.wfsj.org/course/ орчуулан сэтгүүлчдийн ширээний ном, гарын авлага болгохын дээр сэтгүүл зүйн сургалт явуулдаг дээд сургуулиудад заах онолын болон дадлагын хичээлийн хөтөлбөр боловсруулах ажлыг эхний ээлжинд хийхээр төлөвлөж байна” гэсэн юм.

Монголын Шинжлэх ухааны Сэтгүүлчдийн клуб Дэлхийн Шинжлэх ухааны Сэтгүүлчдийн Холбоонд гишүүнээр элсэх хүсэлтээ тавиад байна. Дэлхийн Шинжлэх ухааны Сэтгүүлчдийн Холбоо

Дэлгэрэнгүй мэдээллийг: www.wfsj.org

“19 дүгээр зүйл ба хараат бус сэтгүүл зүй”

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдсаны 60 жилийн ойг тохиолдуулан уг тунхаглалын 19 дүгээр зүйлийн үзэл санаанд тулгуурлан “19 дүгээр зүйл ба хараат бус сэтгүүл зүй” сэдэвт дугуй ширээний ярилцлагыг амжилттай зохион байгууллаа. Сэтгүүл зүйн багш, хараат бус хэвлэл мэдээллийн шинжээч, судлаачид, төрийн бус байгууллагын төлөөлөл болох 42 хүн оролцож Монголын хэвлэл мэдээллийн салбарт болон сэтгүүлчдэд тулгамдаж буй асуудлуудад баг болон ажиллаж бэлтгэсэн илтгэлүүдийг хэлэлцүүлсэн байна.

Ярилцлагад оролцогчид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний өнөөгийн байдал, түүнд нөлөөлж буй орчны талаар хэлэлцүүлэг өрнүүлэн эрх зүйн орчин ба цагдан хяналт, мэргэжлийн сэтгүүл зүйд тулгамдсан асуудлууд, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт гэсэн үндсэн гурван багц асуудалд анхаарлаа хандуулсан байна.

Дугуй ширээний ярилцлагаар дараах илтгэлийг хэлэлцлээ.

19 дүгээр зүйл ба эрх зүйн орчин.

Х.Наранжаргал /“Глоб Интернэшнл” ТББ-ын тэргүүн/

Монголын хэвлэл мэдээлэл Өнөөдөр

Г.Гүнжидмаа /“Хэвлэлийн Хүрээлэн” мэдээлэл судалгааны алба/

Хэвлэлийн эрх чөлөө ба бодит байдал

Ж.Батбаатар /МУБИС-ийн сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч/

Сонгуулийн “бизнес” мэдээ

Д.Цэрэнжав /Хэвлэл мэдээллийн ажиглагч/

Зар сурталчилгаа ба хараат сэтгүүл зүй

Д.Дагиймаа /ХИС, сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч/

Телевизийн халз мэтгэлцээний хөтлөгч

Л.Ариун /ХИС-ийн сэтгүүл зүйн багш/

Сонины хэл найруулга

М.Наранмандах /“Соёл Эрдэм” ДС, сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч/

Редакцийн хараат бус байдал

Д.Доржхорол /“Хэвлэлийн Хүрээлэн”, мэдээллийн төвийн менежер/

Монголын хэвлэл мэдээлэл хэний гарт байна вэ?

Б.Галаарид /Сэтгүүлч/

Хэвлэл мэдээлэл: Бид зохицуулах уу, Ц.Нямдорж зохицуулах уу?

Ц.Онон /сэтгүүлч/

Сэтгүүлчдийн эрхийг хамгаалахад үйлдвэрчний эвлэлийн гүйцэтгэх үүрэг

Ч.Чойсамба /МУИС, сэтгүүл зүйн сургуулийн багш/

Ярилцлагад оролцогчид Монгол улс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжихэд тодорхой ахиц дэвшил гарсан гэдгийг цохон тэмдэглээд цаашид хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг зохицуулсан, орчныг бэхжүүлэхэд чиглэсэн хуулиудыг батлах, сэтгүүл зүйн салбарт Хэвлэл мэдээллийн Зөвлөл, Сэтгүүлчдийн Үйлдвэрчний Эвлэл байгуулах зэргээр өөрийн зохицуулалтыг хөгжүүлэх, сэтгүүл зүйн сургалтыг дэмжих, өргөжүүлэх, давтан сургахад чиглэгдсэн арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай байгаатай санал нэгдсэн байна.

Дэлгэрэнгүйг.

<http://www.globeinter.org.mn/?cmd=Record&menuid=4>

Гарын авлага

“XIX зүйл. Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй”



“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага үүсэн байгуулагдсан цагаасаа Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын XIX зүйл, түүнд нийцүүлэн баталсан олон улсын эрх зүй, хэм хэмжээг олон нийт, сэтгүүлчдэд таниулахыг хичээн, янз бүрийн төслийн хүрээнд олон бичиг баримт орчуулан иргэд, сэтгүүлчдэд зориулсан гарын авлага, ном товхимол хэвлэсэн юм. Сэтгүүлчдийн хүсэлтийн дагуу тэдгээр материалыг эмхэтгэн Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдсаны 60 жилийн ойг тохиолдуулан “Глоб Интернэшнл” ТББ-аас АНУ-ын элчин сайдын яамны санхүүжилтээр “XIX зүйл. Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй” гарын авлагыг бэлтгэн хэвлүүллээ.

Мэдээ, мэдээ, мэдээ

Мэдээллийн урсгалыг малчид руу чиглүүлнэ

“Глоб Интернэшнл” ТББ-аас Францад төвтэй Интерньюс-Европ байгууллагатай хамтран “Бизнес Роаминг” төсөл хэрэгжүүлж эхлээд байна. Төсөл нь Монгол улсын хөдөө орон нутгийн нүүдэлчин ард түмний амьжиргаатай холбоотой бизнес мэдээллийн урсгалыг хөгжүүлэх үндсэн зорилготой бөгөөд төслийн төгсгөлд хөдөө орон нутгийн бизнесийн мэдээллийн агентлаг байгуулагдах юм.

Мэдээллийн агентлаг нь тархан суурьшсан хөдөө орон нутгийн нүүдэлчин ард түмний дунд дунд Мэдээлэл харилцаа холбооны шинэ технологийг ашиглан бизнес мэдээллийн хөгжлийг дээшлүүлэх амьжиргаатай холбоотой бизнес мэдээллийн урсгалыг хөгжүүлэх, салбарын бизнестэй холбоотой мэдээллийн ажиллагаа бий болгоно.

Энэхүү төслийг -нд нэгэн зэрэг хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн үр дүнг Төв болон Дундад Азийн бусад оронтой харилцан туршлага солилцох байдлаар түгээн дэлгэрүүлнэ.

“Бизнес Роаминг” төслийн хүрээнд Өвөрхангай



аймгийн Арвайхээр хотод малчдад зориулсан сургалтыг амжилттай зохион байгууллаа. Сургалтанд тус аймгийн 19 сумаас багийн дарга 2, малчин бус 2, малчин 15 хүн байснаас улсын сайн малчин 1, мянгат малчин 3 оролцсон байна.

Сургалтад оролцогчид мэдээлэл гэж юу вэ, хэрэгтэй мэдээллийг хэрхэн олж авах вэ, олон мэдээллээс зөв сонголтыг хэрхэн хийх вэ, бизнес эрхлэхэд ямар мэдээлэл хэрэгтэй вэ, бизнесийн санхүүжилтийг хаанаас авах вэ, яаж олох вэ гэдэг талаар мэдлэгтэй болж, мөн Хаан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдтэй танилцаж, гар утас, компьютер, интернэтийн хэрэглээний тухай мэдлэгтэй болж, ашиглах дадлагад суралцлаа.

Оролцогчид бүгд нийтэч, нутаг усныхандаа нэр хүндтэй, мэдээлэл түгээх, өөрийгөө илэрхийлэх чадвартай, гар утастай, гар утсаа орчин үеийн түвшинд ашиглаж сурах эрмэлзэлтэй, компьютер, интернет ашиглаж сурах, цаашид ашиглах хүсэлтэй нийгмийн идэвх сайтай хүмүүс байлаа.

Дэлгэрэнгүйг: <http://www.globeinter.org.mn/cmd=Content&id=732&menuid=732>



Сэтгүүлч таны эрх зөрчигдөж эрх зүйн туслалцаа хэрэгтэй болбол “Глоб Интернэшнл” ТББ-ын хуульч Д.Мөнхбүрэнд burnee@globeinter.org.mn хаягаар хандаарай.

Утас: 324627, 324764

Ц.Балдоржийн нэрэмжит сэтгүүл зүйн дээд шагнал

Мэдээ, мэдээ, мэдээ

Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулав.



**БАЛДОРЖ
САН**

Мэргэжлийн сэтгүүл зүйг дэмжих, сэтгүүл зүйн судлалыг хөгжүүлэх зорилгоор нэрт сэтгүүлч, зохиолч Ц.Балдоржийн дурсгалд зориулан Сэтгүүл зүйн дээд шагнал бий болгосноо “Балдорж” санг үүсгэн байгуулагчид зарлалаа.

Уралдаанд оролцохыг хүсэгчдийн бүтээлийг жилийн турш хүлээн авч, шүүгчдийн бүрэлдэхүүн сар бүр оноо өгөх зарчмаар нэгтгэн дүгнэсээр Ц.Балдоржийн төрсөн өдөр буюу жил бүрийн есдүгээр сарын 20-нд шагналыг гардуулна. Чөлөөт хэвлэлийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж, сэтгүүл зүйн салбарыг мэргэжлийн төвшинд хүргэхийн төлөө ажиллан, шинэ цагийн шинэ түүхийг шинээр бичиглэсэн Ц.Балдоржийн нэрэмжит эл шагналыг 5000 ам.доллар, эрхэм эрхлэгчийн дүр бүхий алтан гэрэгэ дагалдана. Цаашдаа уралдааны номинацийг нэмж, сэтгүүл зүйн бичлэгийн бүх төрлийг хамруулна гэдгээ “Балдорж” санг үүсгэн байгуулагчид амлаж байна.

Дэлгэрэнгүй

http://www.mongolnews.mn/journalism/index.php?option=com_content&task=blogcategory&id=19&Itemid=38

Б.Бямба-Очир БНСУ-д эмчлүүлж байна



“Өнөөдөр” сонины гэрэл зургийн сурвалжлагч Б.Бямба-Очир БНСУ-ын Сөүл хотын Анагаах ухааны Их сургуулийн дэргэдэх эмнэлэгт хоёр дахь удаагийн буюу тархины яс нөхөх хагалгааг амжилттай хийлгээд бие нь сайжирч байгаа тухай түүний ээж манайд утсаар мэдээллээ. Б.Бямба-Очир 2008 оны долоодугаар сарын 1-ний үймээний үеэр мэргэжлийн үүргээ гүйцэтгэж яваад халдлагад өртөн дух нь цөмөрч яаралтай хагалгаанд орсон хэдий ч цаашид гадаадын аль нэгэн оронд урт хугацааны эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон.

“Глоб Интернэшнл” ТББ Б.Бямба-Очирын хагалгааны зардалд хандив өргөхийг гадаадын сэтгүүлчдэд хандан олон улсын сүлжээгээр түгээж хөрөнгө босгох аян зохион байгуулснаар Олон улсын сэтгүүлчдийн холбоо, Норвег, Даний сэтгүүлчдийн холбоо тус бүр 1000 евро, Канадын чөлөөт илэрхийллийн төлөө сүлжээний сэтгүүлчид 1 500 канад доллар нийт 3000 евро, 1500 канад доллар олж хандивласан юм. Б.Бямба-Очирын хоёр дахь хагалгааны дараа МоАХ-ноос түүний цаашдын эмчилгээнд зориулж 1000 ам доллар хандивлажээ.

“Ийгл” телевиз

“Шударга үнэний дуу хоолой”-оор шалгарав

Авлигатай тэмцэх газар “Шударга ёсны шагнал 2008”-ын хэвлэл мэдээллийн байгууллагад олгох “Шударга үнэний дуу хоолой” шагналаа “Ийгл” телевизид гардууллаа.

Эрхэм зорилгоо “шинэ, шуурхай, шударга” хэмээн тодорхойлдог “Ийгл” телевизийнхэн 2008 оны 2, 3 дугаар улирлын турш “Авлигын эсрэг дуу хоолойгоо нэгтгэцгээ” аяныг зохион байгуулжээ. Аяны хүрээнд “Өөрсдөөсөө эхлэн шударга байцгаая” хэмээн үзэг нэгт нөхдөө уриалан хэвлэл мэдээллийн байгууллагуудын дунд хэлэлцүүлэг, мэтгэлцээн зохион байгуулсны зэрэгцээ үзэгч түмнээ авлигын эсрэг үйл ажиллагаанд уриалан дуудсан богино хэмжээний шторк, ролик байнга цацаж, энэ чиглэлийн нийтлэл, нэвтрүүлгүүдийг түлхүү бэлтгэж байжээ. Түүнчлэн авлига, хүнд суртлын эсрэг төрийн байгууллагуудын явуулж буй үйл ажиллагааг сайшаан сурталчилж, иргэдийн гомдол мэдээллийн мөрөөр шуурхай сурвалжлан ажилласан байна.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагаас Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулан УИХ-ын дарга Д.Дэмбэрэл, дэд дарга Н.Энхболд, Г.Батхүү, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц. Нямдорж нарт хүргүүллээ.

Олон нийтийн хяналт, хариуцлагын механизмыг боловсронгуй болгох, ОНРТ-ийн төрөөс болон санхүүгийн хувьд хараат бус байдлыг улам баталгаажуулах гэсэн үндсэн хоёр чиглэлээр хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага тавигдаж байна.

Энэ хуулийн төсөл батлагдсанаар Үндэсний зөвлөл, Хяналтын зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүн тодорхой болж, хараат бус байдлыг улам бэхжүүлж, хяналт хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгосноор Олон нийтийн радио, телевиз, Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үр нөлөө дээшлэн, улмаар хуулийн үзэл санаа, зарчмын хэрэгжилт сайжирч, Олон нийтийн радио, телевизийг жинхэнэ утгаар нь хөгжүүлж, төлөвшүүлэхэд тодорхой ахиц гарна гэж үзжээ.

ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газраас тус хуулийн төслийг ойрын үед Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. **Дэлгэрэнгүй:**

<http://www.globeinter.org.mn/?cmd=Record&menuid=4>

“Олон нийтийн Зөвлөлийг чадавхжуулж авлигыг бууруулъя”

“Глоб Интернэшнл” ТББ нь “Ил тод байдлын төлөө түншлэлийн сан”-гийн дэмжлэгтэйгээр “Олон нийтийн Зөвлөлийг хүчирхэгжүүлж Авлигыг бууруулъя” төслийг 2009 оны 01-р сараас эхлэн хэрэгжүүлэх гэж байна.

Төсөл нь 6 сарын хугацаанд хэрэгжих бөгөөд Олон нийтийн зөвлөлийг чадавхжуулах замаар Авлигатай Тэмцэх Үндэсний Зөвлөлд авлигыг бууруулахад нь бодитой хувь нэмэр оруулах зорилготой юм. Энэхүү зорилгоо биелүүлэхээр төсөл хэрэгжих зорилтуудыг хангаж ажиллана.

Төслийн үр дүнд ОНЗ-ийн ажиллах сайн хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, үйл ажиллагааны журмыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд туслах зөвлөмж гарч ОНЗ, ТББ-ууд болон иргэний нийгмийн бусад хэсгүүдийн хоорондын хамтын ажиллагааг сайжирсан байна. Ингэснээр иргэд, олон нийт АТГ-ын ОНЗ-ийн талаар сайн мэдээлэл авч оролцоо нь нэмэгдэнэ.

Ингэснээр иргэд, олон нийт АТГ-ын ОНЗ-ийн талаар сайн мэдээлэл авч авлигатай тэмцэхэд оролцоо нь нэмэгдэнэ. Олон Нийтийн Зөвлөлийг чадавхжуулах баг 7 хүний бүрэлдхүүнтэй ажиллаж байна.

“Байгаль орчны сэтгүүлч”

Нээлттэй нийгэм форумаас Нидерландын Засгийн газрын санхүүжилтээр байгаль орчны асуудлаар хэрэгжүүлж буй төслийн хүрээнд “Байгаль орчны сэтгүүлч” төсөл хэрэгжүүлжээ. Байгаль орчны сэтгүүлчдийн ур чадварыг дээшлүүлэх, иргэд, олон нийтэд хэвлэл мэдээллээр дамжуулан хүргэх мэдээллийг илүү бодитой, хүртээмжтэй болгох зорилгоор 10 сарын хугацаанд 30 гаруй сэтгүүлчид байгаль орчны тулгамдсан олон

сэдвээр хичээл заасан байна. Төслийн явцад Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос эрхлэн гаргасан “Байгаль орчны сэтгүүлчийн гарын авлага” -ыг орчуулан, нэмж засварлан гаргасны дээр анх удаа “Байгаль орчны сэтгүүлчийн лавлах” номыг бэлтгэн хэвлүүлжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг 456570, 99183333 утсаар лавлаарай.



Хүмүүсээр үнэнийг хэлүүлэх нууц урлаг

Сэтгүүлчдийн мэдлэгийн санд
Эх сурвалжтай харьцах урлаг

1. Тусламж хүс.

Хүмүүс тусламж хүсч юм асуухад дуртай байдаг. Тэднээс болж өнгөрсөн үйл явдлыг ойлгоход минь туслаач гэж хүс. Та бага зэрэг эргэлзэж байгаа эсвэл юу гэхээ мэдэхгүй байгаа бол юу болсныг ойлгож авах хэрэгтэй шүү дээ. Хүмүүс мэдэж байгаагаа хэлснээр танд тусалж байна.

2. Бэлтгэлтэй бай.

Та юуны тухай ярих гэж байгаагаа мэд. Тэд юуны тухай ярьж байгааг ойлго, сэдвийн, гарчгийн нэр томъёог судал. Асуултуудаа урьдчилан бэлд. Ямар хариулт ирэхийг бод. Мэдлэгээрээ бүү гайхуул. Гэхдээ түүнийгээ ярилцлагыг өдөөх, хариулт олж авахад ашигла.

3. Сонс.

Сайн сурвалжлагч бол сайн сонсогч байдаг. Зарим үед “М-М-М”, “Яагаад”, “Яаж”, “Та түүгээрээ юу хэлэх гэсэн юм бэ?”, “Би ойлгосонгүй” гэх мэт богино асуулт нь сонсож байх явцад хүмүүсийг яриулаад л байдаг.

4. Шударга бай.

Таны эх сурвалж танд шударга хандаасай гэж та хүсдэггүй гэж үү? Хэрэв та тэдэнтэй харилцан итгэж байхыг хүсч байвал тэдэнтэй шударга бай. Энэ нь эхний асуулт тавихаасаа өмнө бүх зүйлээ дэлгэ гэсэн зүйл биш. Гэхдээ нуугдмал байхаасаа илүү чин сэтгэлээсээ байхыг хичээ.

5. Хүн бүртэй ярилц.

Эх сурвалжуудыг олох шидэт дүрэм байдаггүй. Таны эрж хайж байгаа зүйлийг ямар хүмүүс мэдэж байж болох талаар төсөөлөн бод. Тэдэнтэй бүгдтэй нь ярилц. Асуугаад бай. Эргэж оч, мөн урагшаа яв. Та нэг хэсгийг нь эндээс, нөгөө хэсгийг нь өөр газраас олж магад.

6. Хүмүүстэй нүүр тулж уулз.

Та утсаар нүд рүү нь харж чадахгүй. Ажил тарж нарийн бичгийн дарга нь явсны дараа, дарга нь ажлаа хийхээр үлдсэн, ярилцаж байх үед тань саад болохоор хүн хүлээж авахгүй, утас дуугарахаа больсон үед түүний өрөөнд ор. Оройн цагаар эсвэл амралтын өдрүүдэд гэрт нь очиж хонхыг нь дар. Хүсэж хүлээгээгүй үед нь гэнэт оч.

7. Эргэж оч.

Дахин дахин эргэж оч. Хаалгыг нь үргэлжлүүлээд тогшоод бай. Та тэнэг мэт харагдаж болох ч найрсаг бөгөөд шургуу бай. Тусламж хүсээд л бай. Та тэнэг харагдаж байгаагаа мэдэрч байх үед асуулт тавихад хэцүү байж болно. Гэхдээ нэг дүрмийг сана. Нэгэн сурвалжлагчийн дүрэм: “Сандаргасан асуулт гэж байдаггүй, зөвхөн сандраасан хариулт гэж байдаг” гэжээ.

8. Найрсаг бай.

Жижигхэн яриа үүсгэ. Даруу төлөв бай. Мөн хэрэгтэй үед энэрэнгүй зөөлөн байхыг хичээх хэрэгтэй. Найз байхыг хичээ, гэхдээ үргэлж сурвалжлагч гэдгээ сана.

9. Илэрхий тодорхой асуултыг санаж бай.

Хэрэв хүмүүс таны гол асуултыг үгүйсгээд булзааруулаад байвал, эсвэл таныг өөр зүйл рүү хөтөлбөл та эргэж асуудалдаа орох ёстой. Асуултынхаа үгийг өөрчил, өөрөөр асуух замаар, ойлгомжтой итгэл төрүүлэхээр асуу, хариулт автлаа асуу, хичнээн асуух ёстой төдийчинээ асуу.

10. Эх сурвалжаа уриалан дууд.

Тэдэнтэй бага зөрөлд. Хялбар тайлбарыг бүү хүлээж ав. Би ойлгохгүй байна гэж хэл. Бусад хүмүүсээс мэдэж авсан зүйлээс минь өөрцгий байна гэж хэл. “Та итгэлтэй байж яаж чадах юм бэ?” гэж асуу. Тэднийг илүү тодорхой, бусад хүмүүсийн нэр, ямар нэг баримт материалаар нотлохыг хүс.

11. Өөрийн эх сурвалждаа хэзээ ч бүү итгэ.

Наад зах нь бүрэн бүү итгэ. Дахин шалга. Зөвхөн нотолгоог бус бас няцаалт болох эсрэг нотолгоо хай. Таны хамгийн сайн эх сурвалж ч төгс ой ухаантай байж чадахгүй.

12. Сурвалжлагч нартай байнга бүү нийл.

Үйл явдал нь нийтлэгдээгүй хүмүүстэй нэгд. Урьд уулзаж байсан бүх найз нараа сана. Зарим үед сургууль дээр уулзаж болзож байсан хүн шүүхийн байгууллагын том албаны хүн болчихож ч болно. Хэн нэгнийг хэзээ ч байж байдаг эх сурвалж гэж бүү дутуу үнэл, бүү басамжил.

13. Хэрэв өөрийн эх сурвалжийг хамгаалахыг хүсч байгаа бол

Ялангуяа таны дадлагажигч хамгийн чалчаа сурвалжлагчид /мэдээж таныг оруулахгүйгээр/ болон хэнд ч бүү хэл. Муу нэр хүнд хамгийн сайн сурвалжлагчийг ч сүйрэлд хурдан хүргэнэ.

14. Та дүрмээ гарга.

Хэрэв шаардлагатай бол болзол нөхцөлөө эхнээсээ нэг бүрчлэн ярилцаж хоёулаа ойлголцсон байх хэрэгтэй. Ямар нэг байдлаар хэрэг болохгүй, бичлэг хийгдэхгүй мэдээлэл бүү ав, мөн энэ талаар өөрийн эх сурвалжуудаа ойлгуул. Оройтсон хойно эх сурвалжаараа дүрмээ өөрчлүүлэхгүй бай. Үйл явдлыг олон нийтэд хүргэх нь таны ажил болохоос хэзээ нэг өдөр ач хүүхдүүддээ хэлж суух зүйл биш юм.

15. Хамгийн адгийн дайсандаа ч шударга цохилт өг.

Түүнд хамгийн сайн хамгаалалт хийх боломжийг нийтлэгдсэн өгүүлэлдээ үргэлж гаргаж өгч бай. Хэдийгээр та үүнд итгэхгүй байгаа ч уншигчид өөрсдөө тунгаан бодож үзэх боломж олго. Та түүний хүндлэлийг хүлээж ч болно. Тэр сүүлд нь магадгүй бүх үйл явдлыг танд ярьж өгөх ч юм билүү.

16. Хэрцгий догшин бай.

Энэ нь бичигдээгүй дүрэм. Бүх зүйл дууссаны дараа, гэхдээ баримтуудаа хараахан гаргаж тавиагүй байхдаа байж болох газарт нь унага. Танд одоо найз нөхөд гэж байхгүй. Та сурвалжлагч, тиймээс үнэнийг хэл. Гэхдээ хүмүүст ял шийтгэлийг хэрэгцээгүй бүү тулга. Та сурвалжлагч болохоос бурхан биш. Хүмүүст өөрийнхөө төлөө үг хэлэх бололцоо олго.

17. Үргэлж баярлалаа гэж хэлж бай.

Өгүүллээ бичиж дууссаны дараа эргэж очоод баярлалаа гэж дахин хэл. Ямар нэг зүйл тохиолдоогүй байсан ч эх сурвалждаа баярлалаа гэж хэл. Сайн сонсогч байсан танд баярлалаа гэж шударгаар хэлэх үг маш ховор бөгөөд урам өгөх мэт болдог.

18. Оролдоод бай.

Ажиллаад бай. Энэ нь гэнэтийн ил гарсан жижиг зүйлүүдийг баттай болгох хүнд хүчир ажил юм. “Би олон азтай сурвалжлагчтай уулзаж байсан. Харин би залхуу мөртлөө азтай сурвалжлагчийг мэдэхгүй юм байна” гэж нэгэн туршлагатай хүн хэлсэн гэнэ.

Эдгээр зөвлөмжийг David Hayes, Kansas City Times /82 Пультижерийн шагналт/, Мэрилэндийн Их сургуулийн профессор Карл Стен, Missouri-ийн их сургуулийн Профессор Стив Вайнберг нарын тусламжтайгаар Жамес Полк, IBC News /74 дахь Пультижерийн шагналт/ боловсруулжээ.



И-мэйл хаяг Таны нэр хүнд, имижийн салингүй хэсэг мөн



Хэвлэлийн Хүрээлэнгээс

...@media.mn бүхий И-мэйл хаяг нээж өгөх үйлчилгээг санал болгож байна. Сэтгүүл зүйн салбарт ажиллаж буй хэн бүхэн, сэтгүүл зүйн сургуулийн багш, оюутнууд ч уг үйлчилгээнд ямар нэг үнэ төлбөргүйгээр хамрагдах боломжтой.

Хэвлэл мэдээллийн орчин дахь таны нэр хүнд, эзлэх байр суурийг тодорхойлоход И-мэйл хаяг чухал үүрэгтэй байдаг. Бидний Танд олгосон ...@media.mn хаяг таныг Монголын хэвлэл мэдээллийн салбарын төлөөлөгч гэдгийг илтгэх болно. Тангтай ажил хэргээр харьцах хүмүүст yahoo, hotmail гэх мэтийн хаяг өгөх нь зохимжгүй. Учир нь эдгээр нь нийтийн хэрэглээнд зориулсан, хувийн хаяг юм.

Та шинэ хаягаа албаны хэрэгцээндээ ашиглахаас гадна бид Хэвлэлийн Хүрээлэнд болох хэвлэлийн бага хурлын тухай зар болон бусад үйл явдал, тэтгэлэгт сургалтын тухай мэдээллийг таны хаягаар илгээж байх болно.

Хэрэв Та ...@media.mn хаягтай болохыг хүсвэл Хэвлэлийн Хүрээлэнгийн Интернет төвд /99136014/ хандах буюу <http://webmail.media.mn/index.php> хаягаар захиалан авч болно.

Шинэ ном

Монголын тогтмол хэвлэлийн экологийн нийтлэл

Хүмүүнлэгийн Ухааны их сургуулийн багш, сэтгүүл зүйн



доктор Л.Ариун байгаль орчны сэдвийг тогтмол хэвлэлд хэрхэн тусгаж байгаа асуудлыг сонгон авч судалжээ. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд “Үнэн”, “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ”, “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” зэрэг өдөр тутмын таван сонины есөн жилийн, 36 сарын 245 дугаарт экологийн сэдвээр бичиж нийтлүүлсэн 400 гаруй нийтлэлд задлан шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгсөн байна.

Сэтгүүлчид ХДХВ/ДОХ-ын эсрэг



МУЗН, Австралийн Засгийн газар, Австралийн Улаан Загалмайн Нийгэмлэгээс 2006 оны 9 дүгээр сараас эхэлсэн “Сэтгүүлчид ХДХВ/ДОХ-ын эсрэг” төслийн хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч байгаа мэдээлэлд дүн шинжилгээ хийх, сэтгүүлчдэд ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг олгох, тэдэнд үнэн бодитой мэдээлэл түгээх, сургалт, уулзалт зохион байгуулах зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагааг явуулж байгаа юм. Энэхүү товхимлыг БЗДХ/

ХДХВ/ДОХ-ын талаар дагнан бичих сэтгүүлчдэд дэмжлэг болгох зорилгоор бэлтгэжээ

Хэзээ, хаана, юу?

Авилга ба мэдээллийн эрх чөлөө

Хэзээ: 2009 оны 1-р сарын 30-ны өдрийн 10.00-13.00 цагт

Хаана: ХЗДХЯ-ны хурлын 102 тоот танхимд

Юу: Дугуй ширээний ярилцлага

“Глоб Интернэшнл” ТББ-аас Хүний Эрхийг Хангах Үндэсний Хөтөлбөрийн Хорооны Ажлын албатай хамтран “Авилга ба мэдээллийн эрх чөлөө” дугуй ширээний ярилцлагыг зохион байгуулж “Мэдээллийн эрх чөлөө: Манай амлалтууд ба олон улсын хэм хэмжээ”, “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт мэдээлэлтэй байх эрхийг тусгасан нь”, “Ил тод байдлын мөн чанар ба хязгаар, Авлигатай тэмцэхэд мэдээллийн үүрэг”, “Төрийн нээлттэй ил тод байдал, мэдээллийн хангамж”, “Авлига, хүнд сурталтай тэмцэхэд ажил олгогч эздийн үүрэг оролцоо”, “Төрийн ба төрийн бус байгууллагын түншлэл” зэрэг илтгэлийг хэлэлцэнэ.

Дэлгэрэнгүй хөтөлбөрийг:

<http://www.globeinter.org.mn/?cmd=Record&menuid=4>



Дэлхийн сонины холбоо Азийн аялалд урьж байна

“Үүрэн холбоо ба интернетийн шинэ санаачилга” нэртэй энэхүү аялал нь 2009 оны 2 дугаар сарын 8-13-ны өдрүүдэд зохион байгуулагдана.

Аяллын зорилго нь сонин эрхлэгч компаниуд үүрэн холбоо, интернетийн сувгийг орлогоо нэмэгдүүлэх эх үүсвэр болгон ашиглаж, хэрхэн амжилт олж буй туршлагыг биечлэн суралцах боломжийг сонин эрхлэн гаргагчдад олгож буй аялал юм.

Японы Токио хотоос эхлэх 6 өдрийн аялал нь Өмнөд Солонгос хүртэл үргэлжилнэ. Аялал нь:

- Asahi Shimbun, Японы үндэсний хамгийн том өдөр тутмын сонин
- 47NEWS and Kyodo News Agency, Японы үндэсний агентлаг бөгөөд мэдээг орон нутагт хүргэх үндэсний вэб порталыг шинээр байгуулсан
- Nikkei, Дэлхийн хамгийн том бизнесийн өдөр тутмын сонин
- Dentsu, Дэлхийн хамгийн том зар сурталчилгааны агентлаг
- JoongAng Ilbo, Өмнөд Солонгосын хамгийн том бизнесийн өдөр тутмын сонин

Дэлгэрэнгүй хөтөлбөртэй танилцах болон аялалд бүртгүүлэхийг хүсвэл дараах вэбсайтаар зочилно уу.

www.wan-press.org/asiantour2009/

Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг VI хороо, Эрх чөлөөний талбай,

Дипломат 95 цогцолбор, 06 тоот.

Утас: 324627, 324764, Факс: 324764, 315326

E-mail: hnanan@globeinter.org.mn, globe@globeinter.org.mn, globenews@globeinter.org.mn

www.globeinter.org.mn, www.monitoring.mn